

НИЙСЛЭЛИЙН ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Гэр бүл, хүүхэд хамгааллын хэлтсийн дарга С.Байгалмаагийн
Вьетнам улсад Хүүхдийн утасны Ази номхон далайн бүсийн
6 дугаар зөвлөгөөнд оролцсон талаар
ИЛТГЭХ ХУУДАС

Хүүхдийн утасны Бодлогын хэлэлцүүлэг болон Ази-Номхон далайн бүсийн орнуудын хүүхдийн утаснуудын ҮI зөвлөгөөнд 2013 оны 11 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд оролцож ирлээ. ОУ-ын энэхүү арга хэмжээг Хүүхдийн утасны ОУБ, Вьетнамын Хөдөлмөр, Хөгжлийн бэрхшээл болон Нийгмийн асуудлаарх яам хамтран зохион байгуулсан. Зөвлөгөөн “Ази-Номхон далайн бүсийн хүүхэд, залуучуудын дуу хоолой” нэртэйгээр Вьетнамын нийслэл Ханой хотод зохион байгуулагдсан.

Хүүхдийн утасны ОУБ нь Хүүхдийн утаснуудын дэлхийн сүлжээ байгууллага бөгөөд 2012 оны 10 сарын байдлаар 141 орны 173 утас гишүүнчлэлтэй, утаснуудаа дэмжих, хүчирхэгжүүлэхийн төлөө ажилладаг байгууллага юм. Ингэхдээ:

- Хөгжлийн бүхий л түвшиндээ явж байгаа утаснуудыг дэмжих;
- Харилцаа холбооны салбартай ажиллаж хүүхдийн утсаар үнэ төлөлгүй холбогдох боломжийг бүрдүүлэх;
- Үндэсний хүүхэд хамгааллын тогтолцоог чадваржуулахын төлөө тус тус ажилладаг.

2013 онд ХУОБ байгуулагдсаны 10 жилийн ойн болж байна. Энэ хугацаанд хүүхдийн утаснууд нь

- 126 сая дуудлагыг тусламж, хамгаалал хэрэгтэй хүүхэд, залуучуудаас хүлээн авсан.
- Утасны тоон дүн мэдээг хүүхэд хамгааллын тогтолцооны дутагдал, сул талдаа анхаарал хандуулах болон хүүхдийн эрхийг сурталчлахад ашиглаж ирсэн байна.

Зөвлөгөөний зорилго:

Бодлогын хэлэлцүүлэг болон бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулах зорилготой байсан ба энэхүү 2 арга хэмээнээс тус тусын үр дүнг хүлээн зохион байгуулсан.

1. Бодлогын хэлэлцүүлэг:

- Хүүхэд, залуусын дуу хоолойгоор дамжуулан хүүхэд хамгааллын тогтолцоонд эерэг өөрчлөлтүүдийг авч ирэх болон хүчирхэгжүүлэх зорилготой бодлогын хэлэлцүүлгийн ОУ-ын болон 5 бүсийн түвшинд зохион байгуулах зорилготой
- Хүүхдэд тулгараад байгаа асуудлуудын талаар ярилцуулахаар бодлого гаргагчид, иргэний нийгмийнхэн болон хувийн секторуудыг нэг дор цуглуулах зорилттой зохион байгуулагдсан.
- Гол судэв нь тоон мэдээллийн анализ, дүгнэлт юм.

Бодлогын хэлэлцүүлгээс хүлээсэн үр дүн:

- ЗГ болон бодлого гаргагчид хүүхдийн утас нь Хүүхэд хамгааллын үндэсний тогтолцооны чухал хэрэгсэл гэдгийг танин мэднэ.
- Утасны тоон мэдээлэл хүүхэд хамгааллын тогтолцооны түлхүүр индикатор болно.
- Үнэгүй, тогтооход амар утасны дугаар нь хүүхдийн утасны үйлчилгээнд ямар чухал вэ гэдгийг Засгийн газрууд танин мэднэ.
- Тоон мэдээлэлд үндэслэн хүүхэд, залуусын хэрэгцээнд нийцүүлэн ЗГ болон бодлого гаргагчид өөрсдийн бодлогоо сайжруулах хүсэл, эрмэлзлэл төрнө.
- 2014 онд Лондонд болох ОУ-ын зөвлөгөөнд тайлагнана.

2. Ази-Номхон далайн бүсийн орнуудын зөвлөгөөн:

- Бүсийн зөвлөгөөний дараагийн 2 өдөрт:
 - Мэдээлэл, хэрэгслэл болон нөөцүүдээ солилцох орон зайг бий болгох
 - Бүсийн оролдлогуудаа хэлэлцэх
 - Хэрэгцээнд суурилсан хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан.


Вьетнам улс нь:

- 91 сая хүн амтай
- 2 улиралтай
- Ханой хот нь 2 дахь том хот.
- 2009 онд хотын зах хэсэгт 2.5 сая, төв хэсэгт 6.5 сая хүн амтай байсан.
- Улаан голынхоо баруун эргээр оршдог.
- 2010 онд 1000 жилийн ойгоо тэмдэглэсэн.

Хурлын эхний өдөр буюу 11 дүгээр сарын 26-ны өдөр:
Зөвлөгөөний албан ёсоор нээж Яамны дэд сайд, ХУОБ-ын Гүйцэтгэх захирал нар үг хэлсэн.



Үүний дараа Ази-Номхон далайн бүсийн 10 жилийн дүн мэдээний танилцуулга, дүгнэлт, зөвлөмжийг ХУОУБ-ын Дүн мэдээний хэлтсийн дарга танилцууллаа.



Үүний дараа “Хүүхэд хамгааллын тогтолцоон дахь хүүхдийн утасны ач холбогдол” нэртэй илтгэлийг ХУОУБ-ын Хөтөлбөрийн дарга Leen Decart тавьсан.



Мөн энхний өдрийн орой буюу хурлын дараа ХУОБ-ын Бодлогын хэлтсийн дарга Leen Decard болон Азийн бүсийн зохицуулагч Leilani нартай Монголын төлөөлөгчдийн баг уулзаж Франц, Ирланд улсуудад туршлага судлах аялал зохион байгуулж өгсөн гүн талархал илэрхийлж, Монгол улс нь 2014 онд Хүүхдийн утасны 1 дугаарыг үр дүнтэй ажиллуулна гэдгээ хэллээ.

Хурлын хоёрдахь өдөр буюу 11 дүгээр сарын 27:


- Азийн бүсэд 30 орны 34 утас гишүүнчлэлтэй. Энэ хуралд 20 гаруй нь оролцсон. 25 бүрэн, 9 дэмжигч гишүүн
- Бүсэд зохион байгуулагдсан ажлын тайлан, 3 ажлын зөвлөлийн ажлын тайлан
- Сэдэвчилсэн илтгэл: “Хүүхдийг хамгаалахад шинэ технологийн ашиглах нь” сэдвээр 3 илтгэл тавигдсан.
- Зэрэгцээ 2 бүлгийн хэлэлцүүлэг:
 - Нөлөөллийн стратегиуд
 - Хүүхэд хамгааллын тогтолцоонд хүүхдийн утасны зохицол
- CHI 2015+Strategy сэдвээр 6 бүлгийн хэлэлцүүлэг:
 - Технологи, сайн туршлага, нөлөөлөл, судалгаа, дүн мэдээ, чанарын үзүүлэлт, бүсчилсэн хандлагын арга гэсэн сэдвээр хийгдсэн. Манай багаас эдгээр бүлгийн ажилд ихээхэн ач холбогдолтой саналуудыг өгч чадсан.

Хурлын сүүлийн өдөр буюу 11 дүгээр сарын 28

- Вьетнамын хүүхдийн утасны байгууллагад зочилсон.



Утасны байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, ярилцлагад оролцлоо.



- Хамтрагч Эмэгтэйчүүдийн үндэсний нийгэмлэгт зочилсон
- Нээлттэй орон зайн хэлэлцүүлэг
- Үнэлгээ, дүгнэлт
- Хаалтын ёслол



2013.12.09

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ТАНИЛЦСАН: ДАРГА

С.БАЙГАЛМАА
Я.БАЙГАЛМАА